



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна. Энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас тэтгэвэр авч буй ахмадуудын орлогын баталгааг сайжруулах шаардлага үүсээд байна.

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэврийг ижил хувь, хэмжээгээр нэмэгдүүлж ирсэн нь тэтгэврийн зөрүү үүсэх үндсэн шалтгаан болсон. Энэхүү зөрүүг арилгах зорилгоор даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хэлс, түүнтэй адилтгах орлогыг өнөөгийн цалин хөлсний түвшинтэй жишиж ойртуулахад итгэлцүүрийн аргачлал ашиглаж байна. Уг итгэлцүүрийг Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор суурь оныг 2011 он болгон шинэчлэн баталснаас хойш өөрчлөгдөөгүй байгааг 2022 он болгож шинэчлэх шаардлагатай байна.

Түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого өсөх тул сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн батлах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс бонд, үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг тогтоохтой холбогдуулан шинээр зүйл нэмэх, мөн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн орлого, зарлагын хэмжээнд оруулах өөрчлөлтийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдаж тэтгэврийн зөрүүг арилгах цалингийн итгэлцүүрийг шинэчилснээр 164.6 мянган хүний тэтгэвэр нэмэгдэх бол итгэлцүүр ашиглан тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн зардлыг 10 хувиар нэмэгдүүлснээр 496.3 мянган хүний тэтгэврийн хэмжээ нэмэгдэх болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй байна.

--- oOo ---